



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А/270

Алтай хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн Үндсэн чиглэлийн 4 дүгээр бүлгийн 4.1.1 дэх зорилт, Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.5.1 дэх зорилтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Газар тариалан, жимс жимсгэнэ" төсөл арга хэмжээний хүрээнд нийлүүлэгдэх жимс жимсгэний суулгац, үр, үрсэлгээ хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

- Ажлын хэсгийн дарга: Д.Батбилэг (аймгийн Засаг даргын зөвлөх)
- Гишүүд:
- Т.Сүхбаатар (Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
 - Б.Гайтав (Хүнс, хөдөө аж ахуйн газрын газар тариалангийн үйлдвэрлэл, технологи хариуцсан мэргэжилтэн)
 - Н.Баярмаа (Хүнс, хөдөө аж ахуйн газрын архив, бичиг хэргийн ажилтан, нярав)
 - Г.Төгсбилэг (Мэргэжлийн хяналтын газрын ургамал, хамгаалал, хорио цээрийн хяналтын улсын байцаагч)
 - Х.Лхамноржин (Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн жимс, жимсгэнэ газар тариалангийн багш)
- Нарийн бичгийн дарга: С.Баярмаа (аймгийн Засаг даргын Тамгын газрын хүнс, хөдөө аж ахуйн бодлого хариуцсан мэргэжилтэн)

2. Суулгацыг хүлээн авч, сумдад хуваарилан хүргэх ажлыг шуурхай зохион байгуулж захирамжийн хэрэгжилтийг Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

ОРЛОГЧ

Д.АЛТАНЗАГАС